



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/59

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.4.5, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2015 оны А/198 дугаар захирамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.3, 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. БНХАУ-ын жуулчдад зориулсан Улаанбаатар хотын аялал жуулчлалын танилцуулгыг хятад хэл дээр бэлтгэх ажлыг бага үнийн санал ирүүлсэн “Тэр их жуулчин” ХХК-иар гүйцэтгүүлсүгэй.
2. Гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг мэргэжилтэн /М.Болортуяа/-д үүрэг болгосугай.
3. Гэрээт ажлын урьдчилгаа төлбөр болох 1.500.000 /нэг сая таван зуу/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Э.БАТТУЛГА

